



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар A/01

Мандалговь

**Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх  
жил болгон зарлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газраас байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан, албан хаагч, иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, зорилгоор 2022 оныг “Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх жил” болгон зарласугай.

2. Улсын байцаагч, ажилчид бэлтгэсэн сургалтаа үйлдвэр үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын удирдлага, ажилчдад цахим болон танхимаар чанартай зохион байгуулж ажиллахыг даалгасугай.

3. Сургалтын үр дүнгээр хяналт шалгалт, зөвлөн туслах, бусад хяналт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллахыг улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

4. Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг болосруулан батлуулж, чанартай сургалтыг иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад зохион байгуулах, үр дүнг ажилтан бүртэй тооцож ажиллахыг хэлтсийн дарга, лабораторийн эрхлэгч нарт даалгасугай.

ДАРГА



Ш.ТӨРБАТ